

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
2021 ОНЫ ЖИЛ ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн
<b>Зорилго 1. Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг эрхлэн явуулах, төсөв, санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, удирдах, тайлагнах ажлыг зохион байгуулна.</b>							
1.1	Улсын төсөвт орлого төвлөрүүлэх, бүртгэх, биелэлтийг тайлагнах ажлыг зохион байгуулна.	-	235.4 тэрбум төгрөг	131.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.	235.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.	Холбогдох хууль, журмын дагуу байгууллагын санхүү, аж ахуй, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, шаардлагатай мэдээ, тайланг гарган холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлсэн. Ашигт малтмал, газрын тосны газраас 2021 онд улсын төсөвт 11 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар нийт 249,0 тэрбум төгрөг төвлөрүүлэн бүртгэж, тайлагнасан.	
1.1.1	Улсын төсөвт 2021 онд нийт 235.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх, бүртгэх, биелэлтийг тайлагнах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах	-	Орлогыг тухай бүр төвлөрүүлж, бүртгэсэн байдал, дүн тооцоог сар бүрийн 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.	131.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.	Төвлөрүүлсэн орлогын дүнг сар бүр Сангийн яамтай тооцоо нийлж, акт үйлдсэн байна.	Ашигт малтмал, газрын тосны газраас 2021 онд улсын төсөвт 11 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар нийт 249,0 тэрбум төгрөг төвлөрүүлэн бүртгэж, тайлагнасан. Үүнээс: <ul style="list-style-type: none"> <li>Газрын тосны борлуулалтын орлого 180,4 тэрбум төгрөг;</li> <li>Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого 31,5 тэрбум төгрөг;</li> <li>Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн орлого 3,8 тэрбум төгрөг;</li> <li>Бусад орлого 3.6 тэрбум төгрөг;</li> <li>Төсөвт байгууллагын өөрийн орлого буюу Сонгон шалгаруулалтын орлого 29.6 тэрбум төгрөг байна.</li> </ul>	
<b>Зорилго 2. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, сургалт, давтан сургалт, нээлттэй ил тод байдал, мэдээлэл сурталчилгаа, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, гамшгаас хамгаалах ажлыг зохион байгуулна.</b>							
2.1	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангана.	-	Холбогдох хууль, журам, стандартын дагуу ажиллана.	Хууль, журам, стандартыг 100% мөрдөн ажилласан.	Хууль, журам, стандартыг 100% мөрдөн ажилласан байна.	Хүний нөөцийн удирдлагаар хангах, архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол шуурхай эрхлэн явуулах зорилтын хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын боловсон хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 34 тушаал шийдвэр гарсан. Нийгмийн баталгааг хангах асуудлын хүрээнд буцалтгүй тусламж 13, гэр бүлийг дэмжих 4, чөлөө олгох 2, сахилгын болон сануулах 1, нийгмийн асуудал шийдвэрлэх 3, бусад 18 тушаал шийдвэр гарсан байна.</li> <li>Тайлант хугацаанд ажилтан, албан хаагч иргэд болон бусад байгууллагаас 61 албан бичиг, 81 өргөдөл хүсэлт ирүүлснийг албан бичгээр 32, цахимаар 4, тушаалаар 75, утсаар 31 өргөдөл хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн.</li> <li>Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн нэгдсэн системд 2020 оны хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2021 оны 1 дүгээр сард 1 удаа,</li> </ul>	

						томилсон чөлөөлсөн албан хаагчдын мэдээллийг тухай бүр 34 удаа системд шинэчлэн байршуулсан.
2.1.1	Байгууллагын боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тогтмол, шуурхай зохион байгуулах, хүний нөөцийн судалгаа хийх, санал боловсруулах	-	Хуулийн хүрээнд шуурхай, алдаа дутагдалгүй ажилласан эсэх	Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 30, шийдвэр гарсан.	/20 тушаал шийдвэр/ Судалгаа хийж санал боловсруулсан байна.	2021 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын боловсон хүчний Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 34 тушаал шийдвэр гарснаас, ажилд томилох 6, чөлөөлөх 5, ажлаас чөлөөлж ажилд томилох 23 тушаал шийдвэр гарсан. Хүний нөөцийн судалгаа хийх, санал боловсруулах ажлын хүрээнд, ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран байгуулан ажиллаж байгаа бөгөөд, байгууллага дээрээ хүний нөөцийн судалгаа хийж байгууллагын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөөг 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/44 тоот даргын тушаалаар батлуулж, хэрэгжүүлэн ажилласан.
2.1.2.	Байгууллагын ажилтан, албан хаагчид болон бусад байгууллагаас ирсэн өргөдлийг нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэн ажиллах	-	Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн эсэх	75 албан бичиг, 179 өргөдөл хүсэлт шийдвэрлэсэн	60 тушаал шийдвэр	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагч иргэд болон бусад байгууллагаас 61 албан бичиг, 81 өргөдөл хүсэлт ирүүлснийг албан бичгээр 32, цахимаар 4, тушаалаар 75, утсаар 31 өргөдөл хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн. Мөн нийгмийн баталгааг хангах асуудлын хүрээнд буцалтгүй тусламж 13, гэр бүлийг дэмжих 4, чөлөө олгох 2, сахилгын болон сануулах 1, нийгмийн асуудал шийдвэрлэх 3, бусад 52 тушаал шийдвэр гарсан.
2.1.3	Төрийн албаны зөвлөлд шаардлагатай тайлан мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргүүлэх	-	Мэдээллийг үнэн зөв, цаг хугацаандаа гарсан эсэх	Төрийн албаны салбар зөвлөлийн цахим хуудсанд 30 мэдээллийг байршуулсан.	12 мэдээллийг байршуулсан байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн цахим хуудасны хүний нөөцийн системд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам"-ын дагуу шилжилт хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж, шинээр томилогдсон албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг 34 удаа шинэчлэн байршуулсан. Төрийн албаны зөвлөлд 2020 оны хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2021 оны 1 дүгээр сард 1 удаа хүргүүлсэн.
2.2	Агентлагийн үйл ажиллагаа, хуулиар хориглоогүй бүхий л мэдээллийг олон нийт, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй байлгаж, мэдээлэл авах адил тэгш боломжоор хангана.	-	Байгууллагын ил тод байдлыг 100% хангаж ажилласан байна.	2020 онд ил тод байдлыг хангаж ажилласан.	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг 100% хангасан байна.	Ил тод байдлыг хангаж, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд: <ul style="list-style-type: none"> <li>• Төсөв, санхүүтэй холбогдолтой нийт 92 мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 579.4 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг шилэн дансанд оруулсан.</li> <li>• Байгууллагын зарим үйлчилгээг операторын горимд шилжүүлж төрөлжсөн мэдээлэл, лавлагааны утсыг 2021 оны 6 сард нэвтрүүлсэн. 7777-1900 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, гэрээс ажиллаж байгаа ажилтнуудын гар утсанд холбож, хариу өгч байгаа байдалд хяналт тавьж ажилласан.</li> <li>• 2021 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр агентлагийн болон салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 386 мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн.</li> <li>• Байгууллагын цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 164 мэдээ, мэдээллийг байршуулсан.</li> </ul>
2.2.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулах	-	Хуулийн дагуу хугацаанд нь мэдээллийг байршуулна.	111 мэдээлэл, 272.7 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг байршуулсан.	Хүний нөөцийн 10 мэдээ болон бусад мэдээллийг бүрэн байршуулсан байна.	Төсөв, санхүүтэй холбогдолтой тухай бүр 50, сар бүр 30, улирал бүр 3, жилдээ нэг байршуулах 5, хагас жилд 4, нийт 92 мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулсан. 2021 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 260.8 тэрбум төгрөгийн орлого, 318.6 тэрбум төгрөгийн зарлагын, нийт 579.4 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг шилэн дансанд оруулсан.

						Хуульд заасан хугацааны дагуу байгууллагын бүтэц орон тооны мэдээллийг 12 удаа байршуулсан.
2.2.2.	Газрын тосны салбар үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэх, Монгол Улсын Газрын тосны салбарын түүхэн үйл явдал, ач холбогдол, үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний дагуу ажлыг хэрэгжүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд салбарын үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр бэлтгэн нийлүүлнэ.	-	Төлөвлөгөөний дагуу ажлыг хэрэгжүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд салбарын үйл ажиллагааны мэдээ мэдээллийг бэлтгэн нийтлүүлсэн байна.	Газрын тосны салбарын бодлогын хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр таниулах, сурталчлах ажлын чиглэлээр 2 агуулга бүхий дэлгэрэнгүй төлөвлөгөөг төсвийн хамт гаргаж орлогч дарга Ц.Эрдэнэбаярт хүргүүлсэн. Ажлын хэсгийн төлөвлөгөө гаргах асуудлаар 2 удаа хуралдаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1 удаа уулзаж санал солилцсон. Монгол Улсад Газрын тосны салбар үүсэж байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд салбарын бэлэг тэмдэг бүхий логоны загварын уралдааныг Ашигт малтмал газрын тосны газраас график дизайнерууд, зураачид, нийт уран бүтээлчдийн дунд 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрөөс 2 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл хугацаанд нээлттэй зарлаж, шалгаруулав.
2.2.3	Салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, үйл ажиллагааны үр дүнг хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах	-	Үнэн зөв, бодитой мэдээ, мэдээллийг бэлтгэн нийтлүүлнэ.	Нийт 817 мэдээ, мэдээлэл	360 мэдээ, мэдээлэл	Ашигт малтмал, газрын тосны салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв үйл ажиллагааны үр дүнг MYONPT, Eagle TV, UBS TV, TV-5, MNC, Bloomberg, SBN, NTV, TM, TV-25 дугаар суваг телевизүүд болон 26 мэдээллийн сайт, 6 өдөр тутмын сонин, 1 радиогоор дамжуулан хэвлэлийн 84 мэдээ бэлтгэн олон нийтэд мэдээлсэн. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийн 13.2%-ийг салбарын болон агентлагийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, 46.6%-ийг газрын тосны олборлолт, газрын тосны бүтээгдэхүүний хангамж үнэтэй холбоотой мэдээлэл, 10.9%-ийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл, үлдсэн 29.3%-ийг бусад мэдээлэл эзэлж байна.
2.2.4	Төрийн цахим шилжилтийн бодлого, арга хэмжээг байгууллагын хэмжээнд төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулах	-	Төлөвлөлтийн дагуу цахим шилжилт хэрэгжсэн байна. 20%	0%	20%	<ul style="list-style-type: none"> <li>Байгууллагын зарим үйлчилгээг операторын горимд шилжүүлж төрөлжсөн мэдээлэл, лавлагааны утсыг 2021 оны 6 сард нэвтрүүлсэн. 7777-1900 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, гэрээс ажиллаж байгаа ажилтнуудын гар утсанд холбож, хариу өгч байгаа байдалд хяналт тавьж ажилласан.</li> <li>Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд зар, мэдээ, мэдээллийг масс мессежээр хүргүүлэх Мессежпро үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сард нэвтрүүлсэн. 2021 оны 11 дүгээр сард төлбөрөө төлж бүртгүүлэх тухай 296, төлөвлөгөө тайлангийн шинэчлэгдсэн програмын сургалтад хамрагдах тухай 1862 мессежийг илгээсэн.</li> </ul>
2.2.5	Агентлагийн веб хуудсыг шинэчлэн, шаардлагатай мэдээ, мэдээллийг оруулж ажиллах	-	Үнэн зөв, бодитой мэдээ, мэдээллийг нийтэлнэ.	156 мэдээ мэдээлэл оруулсан.	180 мэдээ	Байгууллагын цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 164 мэдээ, мэдээллийг байршуулсан.
2.3	Сургалт, давтан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Сургалт, давтан сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.	2020 онд сонгон шалгаруулалтаар 17 суралцагч сонгогдож, 150 албан хаагч сургалтад хамрагдсан.	Сургалтын үйл ажиллагаа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан байна.	2021 оны сургалтын төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлуулсан. Үүний дагуу байгууллагын албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг Агентлагийн даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны А/46 дугаар тушаалаар батлуулсан. 2021 оны 11 дүгээр сарын 8-ны байдлаар 165 албан хаагчид сургалтад хамрагдсан.
2.3.1	Агентлагийн ажилтан, албан хаагчдыг богино, дунд хугацаат сургалтад	-	Төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж	2020 онд 150 албан хаагч	1 төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж	2021 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн байдлаар 165 албан хаагчид сургалтад хамрагдсан.

	жигд хамруулах ажлыг зохион байгуулах		батлуулах, албан хаагчдыг хамруулна.	сургалтад хамрагдсан.	батлуулсан байна. Албан хаагчдыг төлөвлөгөөний дагуу сургалтад жигд хамруулсан байна.	Монгол улсын Засгийн газрын 2013 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу 2021 оны сургалтын урамшууллын зарцуулалтын төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлуулсан. 2021 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг Агентлагийн даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны А/46 дугаар тушаалаар батлуулсан.
2.4	Гадаад орнуудаас ирүүлсэн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	-	Үр ашигтай зохион байгуулж ажиллана.	1 төсөл хэрэгжиж 1 төсөл хэрэгжихээр судлагдаж байгаа	Хэрэгжүүлэхээр ирүүлсэн төсөл, хөтөлбөр саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	ХБНГУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар ХБНГУ-ын Гео-Шинжлэх Ухаан Байгалийн нөөцийн хүрээлэнгээр дамжуулан хэрэгжүүлж буй “Монгол улсын эрдэс баялгийн салбар дахь институцийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх” төсөл Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оноос хэрэгжиж байгаа бөгөөд төсөл 2020 онд хэрэгжиж дуусах байсан боловч цар тахлын улмаас зарим төлөвлөгөөт ажлууд хийгдэж амжаагүй тул 2021 оныг дуустал 1 жилээр төслийн хугацааг сунгасан. 2019-2023 онд хэрэгжиж буй АМЕП 2 хөтөлбөрийн хүрээнд “Нүүрсний давхаргын метан хийн гео-мэдээллийг сайжруулах нь” төслийг Ашигт малтмал, газрын тосны газар Адам смит Интернэшнл Олон улсын байгууллагатай хамтран 2021-2022 онд хэрэгжүүлж байна.
2.4.1	Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн ажлыг нэгтгэн зохион байгуулж, бүтцийн холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах	-	Үр ашигтай зохион байгуулж ажиллана.	1 төсөл хэрэгжиж 1 төсөл хэрэгжихээр судлагдаж байгаа	Харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн 1 хэрэгжилтийг гаргана.	ХБНГУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар ХБНГУ-ын Гео-Шинжлэх Ухаан Байгалийн нөөцийн хүрээлэнгээр дамжуулан хэрэгжүүлж буй “Монгол улсын эрдэс баялгийн салбар дахь институцийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх” төсөл Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 оноос хэрэгжиж байгаа бөгөөд төсөл 2020 онд хэрэгжиж дуусах байсан боловч цар тахлын улмаас зарим төлөвлөгөөт ажлууд хийгдэж амжаагүй тул 2021 оныг дуустал 1 жилээр төслийн хугацааг сунгасан. Төслийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн материал боловсруулах, бэлтгэн гаргах, CMCS болон E-Reporting системд хөгжүүлэлт, сайжруулалт хийх зэрэг ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдсэн. 2019-2023 онд хэрэгжиж буй АМЕП 2 хөтөлбөрийн хүрээнд “Нүүрсний давхаргын метан хийн гео-мэдээллийг сайжруулах нь” төслийг Ашигт малтмал, газрын тосны газар Адам смит Интернэшнл Олон улсын байгууллагатай хамтран 2021-2022 онд хэрэгжүүлж байна.
2.5	Цар тахлын эсрэг арга хэмжээ авах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллана.	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	Улсын онцгой комисс, Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны шуурхай штабаас ирүүлсэн чиглэлийн дагуу цар тахлын үед уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, уурхай, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, байгууллагын албан ёсны веб сайт, пэйж хуудсаар холбогдох мэдээ мэдээллийг дамжуулж ажилласан.
2.5.1	Цар тахлын үед салбарын уурхай, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажлыг зохион байгуулах, Уурхайн ажилчдын ээлж солилцох ажлыг зохион байгуулахад дэмжлэг	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	Улсын онцгой комисс, Гамшгаас хамгаалах Уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны шуурхай штабаас ирүүлсэн чиглэлийн дагуу цар тахлын үед уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгж, байгууллага, уурхай, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, байгууллагын албан ёсны веб сайт, пэйж хуудсаар холбогдох мэдээ мэдээллийг дамжуулж ажилласан. Мөн Коронавируст (Ковид-19)-ийн эсрэг вакцинд салбарын аж ахуйн нэгж байгууллагууд хамрагдсан талаарх судалгааг нэгтгэж гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд

	үзүүлж мэдээ мэдээллээр хангах					үйлдвэрийн улсын албанд 2021 оны 6 дугаар сарын 10, 2021 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нийт 2 удаа мэйл хаягаар хүргүүлсэн. 2021 онд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгөө батлуулсан ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 223 аж ахуй нэгжээс 2 дугаар сард вакцинжуулалтын 1 дүгээр тун, 6 дугаар сард вакцинжуулалтын 2 дугаар тун, 10 дугаар сард вакцинжуулалтын 3 дугаар тунд хамрагдсан байдлын судалгааг авч нэгтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны онцгой штабын нарийн бичгийн дарга Ш.Эрдэнэцэцэгт 3 удаа хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан.
<b>Зорилго 3. Газрын тосны хайгуул, ашиглалтын өртөг нөхөгдөх зардалд хяналт тавих, газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.</b>						
3.1	Газрын тосны хайгуул, ашиглалтын өртөг нөхөгдөх зардалд хяналт тавих, газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Холбогдох хууль, журам, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцсэн байна.	2020 оны 1-3 дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авсан, төлбөрийг төвлөрүүлсэн.	Төсөв, мэдээ тайланг нэгтгэж, санхүүгийн шалгалт хийх, орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Холбогдох хууль, журам, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 13 талбайн 408.1 сая ам.долларын төсөв батлагдаж, 66.0 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардлын тайланг нэгтгэн, 57.8 сая ам.долларын тосны экспортын орлого болон 1.8 сая ам.долларын төлбөр, урамшууллыг төвлөрүүлсэн.
3.1.1	Гэрээлэгчдээс ирүүлсэн 2021 онд хийх ажлын төлөвлөгөө, төсвийг холбогдох хэлтсүүдтэй хамтран хэлэлцэж батлуулах, өртөг нөхөгдөх зардлын тайланг улирал бүр хүлээн авч, нэгтгэх	-	Төлөвлөгөө, төсөвт санал, дүгнэлт гарган ажилласан эсэх, батлагдсан төсөв, гэрээлэгчдийн ирүүлсэн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн нэгтгэлээр	Гэрээлэгчдийн 2020 оны 1-3 дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч, нэгтгэсэн.	2021 онд хийх ажлын төлөвлөгөө, төсөв батлагдаж, 2020 оны жилийн эцсийн, 2021 оны 1-3 дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч, нэгтгэсэн байна.	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын 2021 оны жилийн ажлын уулзалт зохион байгуулах, төлөвлөгөө, төсөв батлах Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/04 дүгээр тушаал (хайгуул), 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/53 дугаар тушаал (“Доншен газрын тос /Монгол” ХХК), 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/74 дүгээр тушаал (“Петрочайна Дачин Тамсар” ХХК)-аар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд 2021 оны төлөвлөгөө, төсвийг хүлээн авч, Газрын тосны хайгуулын хэлтэс, Газрын тосны ашиглалтын хэлтэстэй хамтран ажиллаж, санал дүгнэлт гаргасан бөгөөд бүтээгдэхүүн хуваах гэрээт 13 талбайн 408.1 сая ам.долларын төсөв батлагдаад байна. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд 2020 оны 4 дүгээр улиралд 95.9 сая ам.доллар, 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 132.4 сая ам.доллар, 2021 оны 1-3 дугаар улирлын байдлаар 66.0 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэсэн.
3.1.2	Гэрээлэгчдийн Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг төлбөрийг тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	-	Төлбөр, урамшууллыг тооцож нэхэмжлэх, төлбөрийн хуваарилалтыг тооцож, дүн мэдээг Сангийн яаманд сар бүр хүргүүлсэн байна.	2020 оны 1-11 дүгээр сард төлсөн нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн хуваарилалтыг тооцож, дүн мэдээг Сангийн яаманд хүргүүлсэн.	100%	Гэрээлэгч компаниудын 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 10 дугаар сард төлсөн нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 20 хувийг тухайн аймаг, нийслэлийн төсөвт, 10 хувийг сум, дүүргийн төсөвт хуваарилах тооцоог аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр хийж, дүн мэдээг сар бүр Сангийн яаманд 4/59, 4/607, 4/1031, 4/1644, 4/1988, 4/2468, 4/2909, 4/3444, 4/3962, 4/4502, 4/4959 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 10 дугаар сард нөөц ашигласны төлбөр нийт 25.7 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 18.0 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 7.7 тэрбум төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөр нийт 1,855.5 сая төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 1,298.8 сая төгрөг, 15 аймгийн төсөвт 371.1 сая төгрөг, 99 (давхардсан тоогоор) сумын төсөвт 185.5 сая төгрөг тус тус хуваарилагдсан байна.
<b>Зорилго 4. Хувийн хөрөнгөөр гүйцэтгэж буй ашигт малтмалын хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөөг хүлээн авах, хайгуулын ажлын зардлыг хянан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд ажлыг газар дээр нь шалгах, ашигт малтмалын нөөцийг өсгөнө.</b>						

4.1	Ашигт малтмалын хайгуулын ажлын үр өгөөжийг дээшлүүлэх, эрдэс баялгийн нөөцийг өсгөнө.	-	Үнэн зөв хийгдсэн байна.	-	Ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн тоо хэмжээгээр	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр орсон 106 тайлангаас ашигт малтмалын нөөцийг ашигт малтмалын 19 төрлөөр ангилан бүртгэж, мэдээг сар бүр шинэчлэн бэлтгэсэн. Бусад хэлтэс болон холбогдох мэргэжилтэнд шаардлагатай үед ашигт малтмалын нөөцтэй холбоотой мэдээллийг 9 удаа бэлтгэж өгсөн.
4.1.1	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тодотгол тайланг хүлээн авч хянах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх, мэдээллийн санг хөтлөх, баяжуулах, мэдээлэл бэлтгэж өгөх	-	Тайланг хянах, хяналтын хуудсаар дүгнэх, санд бүртгэх ажлын хүрээнд ашигт малтмалын төрлөөр бүртгэнэ.	-	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хүлээн авсан 60 тайлангийн тоо хэмжээгээр хийгдсэн байна.	Ашигт малтмалын төрлөөр нь: алтны шороон ордын 12, нүүрс 5, барилгын материалын 9, газрын тос 1, төмөр 2, алтны үндсэн 5, хайлуур жонш-5, манган 2, зэс 1, мөнгө 1 тус тус орж хариуцсан мэргэжилтнүүд нь нэгдсэн мэдээллийн санг баяжуулсан. Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэст Able-ийн захидлаар 2021 оны 2 дугаар сарын 3, 2021 оны 3 дугаар сарын 4, 2021 оны 4 дүгээр сарын 3, 2021 оны 5 дугаар сарын 3-ны өдөр тус тус илгээсэн.
4.1.2	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэх ашигт малтмалын хайгуулын ажлын жилийн тайлан, төлөвлөгөөг хянах, хүлээн авах, мэдээллийн нэгдсэн санг нэмэлт мэдээллээр баяжуулж шинэчлэх, тайлан, төлөвлөгөөг Геологийн баримтын төв архивд тушаах	-	Ирүүлсэн хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөөний тоо хэмжээгээр	2019, 2020 онд тайлан, төлөвлөгөөг Геологийн баримтын төв архивд тушаасан.	Ирүүлсэн хайгуулын ажлын 700 тайлан, хайгуулын ажлын 600 төлөвлөгөөг, архивд хүлээлгэн өгсөн байна.	Илгээсэн хайгуулын ажлын 450 тайлан, хайгуулын ажлын 580 төлөвлөгөөг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх бэлэн болсон.
4.2	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	-	Чанартай үнэн зөв хийгдсэн байна.	-	Сонгон шалгаруулалтаар олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо хэмжээгээр	“Салхитын ам-1” молибдений орд, Цогзол уулын хайлуур жоншны ордод байрлах Өлзийт-1 орд, Цогзол уулын хүдрийн биетүүд, “Дунд Бөхөгийн доод” элс-хайрханы орд, Хөхдэлийн литийн орд, Цагаан давааны гянтболдын орд, Эрдэнэтийн овоо зэс молибдений орд, Ханын хярын газрын ховор элемент-барий-стронцийн орд, Өндөр эрэгийн алтны шороон ордуудын хайгуулын ажлын үр дүнгийн тайлангуудаас нөөц нэмэгдүүлсэн.
4.2.1	Төрөөс тогтоосон талбайд зарласан сонгон шалгаруулалтын талбайн ерөнхий мэдээлэл, геологи, ашигт малтмалын мэдээллийг бэлтгэх	-	Чанартай үнэн зөв хийгдсэн байна.	-	8,4 га талбайд зарлах 450 талбайн мэдээллийг Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст өгнө.	Төрөөс тогтоосон талбайд зарласан сонгон шалгаруулалтын 124 зураг бэлтгэж мөн 157 талбай, баруун бүсийн 17 талбай, говийн бүсийн 25 талбайн өмнөх судалгааны түвшний мэдээллүүдийг бэлтгэж, Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст өгсөн.
4.2.2	Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх ашигт малтмалын хайгуулын ажлыг /төрөөс зөвшөөрсөн газар нутаг/ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	-	Чанартай үнэн зөв хийгдсэн байна.	2020 онд 27 хайгуулын тусгай зөвшөөрлийг хянаж мэдээллийн санд бүртгэсэн.	90 хайгуулын тусгай зөвшөөрлийг тус бүрээр хянаж бүртгэсэн байна.	Шинээр олгогдсон 87 хайгуулын тусгай зөвшөөрлийг хянаж мэдээллийг санд бүртгэсэн. 2020 оны 7 дугаар сараас 12 сар дуустал хугацаанд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар алтны 16 орд, холимог металлын 1 ордын нөөцийн тайлан хэлэлцэгдэж нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгээд байна.

**Зорилго 5. Ашигт малтмалын салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.**

5.1	Ашигт малтмалын салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулна.	-	Хууль, заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэсэн байна.	1	Хуулийн шаардлага хангаж 100% хийгдсэн байна.	Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход саналыг Able-ийн захидлаар 2021 оны 4 дүгээр сарын 30-нд хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэгт удаа дараа оролцож саналаа бичгээр боловсруулж өгсөн. "Монгол Өмгөөлөл" ХХК болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд зохион байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцүүлэгт оролцож саналаа өгсөн.
5.1.1	Ашигт малтмалын салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, аргачилсан зөвлөмжийг боловсруулахад оролцох	-	Санал өгсөн хуулийн тоо	1	2	Хууль эрх зүйн хэлтэст Хилээр дээж нэвтрүүлэх зааварт саналыг Able-ийн захидлаар 2021 оны 4 дүгээр сарын 22-нд өгсөн. Хайгуулын ажлын болон ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах зааварт саналаа өгсөн. Сонгон шалгаруулалтын журам, танилцуулгад саналаа өгсөн. Хилээр дээж нэвтрүүлэх зааварт санал боловсруулж ахлах мэргэжилтэн Ү.Ганбаатарт хүргүүлсэн.
5.1.2	Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад оролцох	-	Санал өгсөн хуулийн тоо	1	2	Газрын багц хуулиуд, дагалдах хуулиуд холбогдох саналыг Able-ийн захидлаар 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. "Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал өгсөн.
5.1.3	Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 22 дугаар зүйл, 33 дугаар зүйл, 48 дугаар зүйл, 56 дугаар зүйлд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж, олон нийтэд хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	-	Хууль, заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэсэн байна.	-	Хуулийн шаардлага хангаж 100% хийгдсэн байна.	Хайгуулын ажлын жилийн тайлангийн цацраг идэвхт металл, газрын ховор элемент, хар, ховор металл ашигт малтмалын 95 тайлан хянаж, засварт буцаасан 35, үнэт, өнгөт металлын 80 тайлан хянаж, засварт буцаасан 26 тайлан. Хайгуулын ажлын жилийн тайланг цахимаар хүлээн авах хэсгээс нийт 310 тайлан хянаж, Геологийн хэсэг рүү 250-г шилжүүлсэн, засварт буцаасан 60. Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн нийт 220 хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө хянаж, үүнээс баталгаажсан 180, засварт буцаасан 40. Хайгуулын ажлын тайлан, төлөвлөгөө илгээх цахим эрхийг нийт 56 аж ахуй нэгжид илгээсэн. Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлсэн болон тухайн жилийн зардлаа баталгаажуулсан тухай тодорхойлолт 388 гаргаж өгсөн. 115 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөөц бүхий хайгуулын ажлын үр дүнгийн тайланд шинжээч, 12 ашигт малтмалын нөөцийн ангилал зааварт шинжээч, нийт 127 шинжээч томилох шийдвэр гарсан. 107 тайланд хяналтын хуудас олгосон.
5.1.4	Цөмийн энергийн тухай хуулийн 11.2.2, 11.2.3-д заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж, олон нийтэд хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	-	Хууль, заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэнэ.	-	Хуулийн шаардлага хангасан 4 удаа мэдээ, мэдээллийг хүргүүлсэн байна.	Цөмийн Энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжаваас ирсэн 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 1/177 тоот албан бичгийг хүлээн авч танилцаж, хариу албан бичиг төлөвлөж хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн 2020 онд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын зардал, үр дүн, 2021 оны төлөвлөгөө, тусгай зөвшөөрлийн төлбөр төлөлтийн мэдээлэл, цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн мэдээллийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар бэлтгэн 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр 13/2073 тоотор хүргүүлсэн.
5.1.5	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгж, олон нийтэд хууль, тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан	-	Хууль, заавар, журамд нийцүүлэн, шуурхай чанартай гүйцэтгэнэ.	-	Хуулийн шаардлага хангаж 100% хийгдсэн байна.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нийт 295 тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд орд илрэлийн шүүлтийг хянасан.

	таниулах ажлыг зохион байгуулах					
<b>Зорилго 6. Стратегийн болон томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж Уул уурхайн салбараас улс орны нийгэм, эдийн засаг, болон байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх, эвдрсэн газрын нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг бүрдүүлэх, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх зүйн орчныг сайжруулах, бичил уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.</b>						
6.1	Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангана.	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.	Оюутолгойн төслийг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулахад холбогдох ажлын хэсэгт ажиллаж, 4 байгууллага, албан тушаалтныг 5 удаа, /Нууцтай холбоотой мэдээллүүд/ Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ажиллахад 4 удаагийн цахим хурлыг хийж, гүйцэтгэлийн талаар мэдээлэл авч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тухай бүр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг мэдээллээр хангаж, Зүүн-цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулахад техник эдийн засгийн үндэслэлтэй танилцаж санал дүгнэлт гарган техник эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авах ажлыг зохион байгуулав.
6.1.1	Оюутолгойн төслийг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулахад шаардлагатай мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	6 мэдээлэл хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>Монгол улсын Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Оюу-толгойн хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэх ажлын хэсэгт техникийн дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсгийн хуралдаанд оролцон санал, дүгнэлт өгч ажиллан, ажлын хэсгийн дарга Барилга хот байгуулалтын Яамны төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд Оюу-толгой төслийн хэлэлцээрт оруулах саналыг боловсруулж 2021 оны 2 дугаар сарын 23-нд хүргүүлсэн. /Нууцтай холбоотой мэдээллүүд/</li> <li>Өмнөговь аймгийн Ханбогд нутагт орших Оюутолгой ордын хайгуулын ажлын үр дүнгийн тодотгол тайлантай холбогдох мэргэжилтэн танилцан, санал дүгнэлт боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэхэд санал дүгнэлт өгч, холбогдох засварыг хийлгэн ажилласан.</li> </ul>
6.1.2	Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад шаардлагатай мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	2 мэдээлэл хүргүүлсэн байна.	Цагаан-суваргын зэс, молибдений ордыг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан-суваргын зэс, молибдений ордын ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлтэй танилцан, санал дүгнэлт боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Цагаан-суваргын зэс, молибдений ордын АМНАТ-ын танилцуулга бэлдэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Т.Баасанпүрэвт 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр <a href="mailto:baasanpurev@gmail.com">baasanpurev@gmail.com</a> цахим хаягаар хүргүүлсэн.
6.1.3	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглахад шаардлагатай мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	6 мэдээлэл хүргүүлсэн байна.	“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн Салхитын мөнгө, алтны ордын төслийн гүйцэтгэлд тогтмол хяналт тавих зорилготойгоор тус уурхайн удирдлагуудтай 2021 оны 2-5 дугаар саруудад 4 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, гүйцэтгэлийн талаар мэдээлэл авч, хурлын тэмдэглэл хөтлөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тухай бүр олборлолт болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар 4 мэдээллийг хүргүүлсэн. Салхитын мөнгө-алтны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлтэй танилцан, санал дүгнэлт боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Салхитын мөнгө-алтны ордын 2020 оны нөөцийн хөдөлгөөнийг хийж үлдэгдэл нөөцийн мэдээллийг аж ахуйн нэгжид хүргүүлсэн.
6.1.4	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулахад	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл	-	2 мэдээлэл хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>Зүүн цагаан дэлийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлтэй хяналтын хуудсаар танилцаж санал дүгнэлт гарган Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн техник эдийн засгийн</li> </ul>



	шаардлагатай мэдээллээр хангах		хүргүүлсэн байна.			үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцүүлэн техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах ажлыг зохион байгуулсан. • Зүүн цагаан дэлийн хайлуур жоншны ордын 2020 оны нөөцийн хөдөлгөөнийг хийж үлдэгдэл нөөцийн мэдээллийг аж ахуйн нэгжид хүргүүлсэн.
6.2	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангана.	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.	• Эрдэнэт үйлдвэр 2020 оны нөөцийн хөдөлгөөнийг хийж үлдэгдэл нөөцийн мэдээллийг аж ахуйн нэгжид хүргүүлсэн. • Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 56 тоот удирдамжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 ажлын явц, үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж хариуцсан хэлтэс цехийн дарга нартай санал солилцов. • Улирал тутам хэрэгжилтийн талаар тайланг хүлээн авч технологи, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөө мэдээллээр тухай бүр нь ханган ажилласан.
6.2.1	Мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	2 мэдээлэл хүргүүлсэн байна.	2021 оны 11 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд ажлын явц, үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж хэрэгжилтийн талаар үйлдвэрийн нэгдүгээр орлогч захирал Н.Батмөнхтэй санал солилцож, технологи, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан. Металл хийц үйлдвэрлэлийн ажлын явц: • Бутлуурын байгууламж - 100% • Туузан дамжуургын систем - 40%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц: • Бутлуурын байгууламж - 90% • Туузан дамжуургын систем - 85%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 17%-ийн гүйцэтгэлтэй байна.
6.2.2	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	2 мэдээлэл хүргүүлсэн байна.	2018 онд батлуулсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийн дагуу барьж байгаа эсэхтэй 2021 оны 11 дүгээр сарын 2-6-ны өдөр танилцан “Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүс тогтоох, тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын дүгнэлт гаргах түр заавар”-ын талаар болон технологи, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан
6.2.3	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 2 мэдээлэл хүргүүлсэн байна.	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил нь зураг төслийн дагуу барьж байгаа эсэхтэй 2021 оны 11 дүгээр сарын 2-6-ны өдөр танилцан баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага болон технологи, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан. Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 99%-тай байгаа ба тоног төхөөрөмжүүдийн нийлүүлэлт хийгдэж байна. БНХАУ-аас эхний ээлжид ирэх 22 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжилтнүүдийн Монгол улсад нэвтрэх визний зөвшөөрөл гарсан.
6.2.4	Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 2 мэдээлэл хүргүүлсэн байна.	Энэ онд техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил хийгдэх ба засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийн техник-эдийн засгийн үндэслэлтэй танилцан, санал дүгнэлт боловсруулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулан ажиллана. Ажлын явц засвар, механикийн заводыг (2020-2024 он) үндэсний машин үйлдвэрийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан

						техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулалт явагдаж дууссан. Гүйцэтгэгчээр “Ди Ди Эй Жи” ХХК шалгарч 2021 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 5/196-21 тоот гэрээг байгуулан ажиллаж байна.-	
6.3	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай мэдээллээр хангана.	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх, хөрөнгө оруулалт татахад шаардлагатай мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.	
6.3.1	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, ажлыг зохион байгуулахад мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	2 мэдээлэл хүргүүлсэн байна.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай далд уурхайн 3 хэмжээст зураглал хийхэд хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажлыг гүйцэтгэх төсвийг 2022 оны төсвийн төсөлд тусгахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.	
6.3.2	Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	2 мэдээлэл хүргүүлсэн байна.	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт татахад шаардлагатай геологи, хайгуулын ажил хийх, дэд бүтэц, уулын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, барилгын ажлыг төлөвлөх, ашиглалтад оруулах бүтээгдэхүүн гаргах талаар шаардлагатай мэдээллээр холбогдох байгууллагыг хангаж ажилласан.	
6.4	Төрөөс Эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн хүрээнд: /2014-2025 он/ Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэдээллээр хангаж, санал хүргүүлнэ.	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	2020 онд шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн.	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.	Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд оруулах бичил уурхайтай холбоотой нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулж, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд нэмэлт өөрчлөлт оруулах 9 санал боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Элбэгзаяа, Техник, технологийн хэлтсийн дарга Ч.Цогтбаатар нарт 2021 оны 5 дугаар сарын 7-ны өдөр албан бичгээр тус тус хүргүүлсэн.	
6.4.1	Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайтай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулахад санал өгөх, мэдээллээр хангах	-	Мэдээллээр хангана. Хэрэгжихүйц санал хүргүүлсэн байна.	2020 онд 1 санал, 3 мэдээ, мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.	2 санал өгч, мэдээлэл хүргүүлсэн байна.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн тушаалаар байгуулсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэргийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэгт хүргүүлэх Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд бичил уурхайн нөхөрлөл нь дүгнэлт гарсан талбайн нөөц, олборлолтын төлөвлөгөө, тайлан боловсруулах болон бичил уурхайн дүгнэлт гаргасан талбайг олгох, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахад геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тавих хяналттай холбоотой нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулж 2021 оны 5 дугаар сарын 7 болон 2021 оны 6 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.	
6.4.2	Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан бичил уурхайгаар ашигт малтмал олборлох	-	Санал хүргүүлсэн байна.	2020 онд журамд оруулах саналыг 2 удаа хүргүүлж,	2 санал өгч, мэдээлэл хүргүүлсэн байна.	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд нэмэлт өөрчлөлт оруулах 9 санал боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Элбэгзаяа, Техник, технологийн хэлтсийн дарга Ч.Цогтбаатар нарт 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 6/1982 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	

	журмыг шинэчлэн боловсруулахад санал өгөх, мэдээллээр хангах			3 мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.		Бичил уурхайн үйл ажиллагаатай холбогдолтой дэлгэрэнгүй мэдээлэл, цаашид авах арга хэмжээний саналыг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд 2021 оны 8 дугаар сарын 8-ны өдөр shuurhai@nsc.gov.mn цахим хаягаар хүргүүлэв.
6.5	Ногоон хөгжлийн 2016-2030 оны бодлогын баримт бичгийн хүрээнд: Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээлгүй орхигдсон газруудын талаарх мэдээ, мэдээллээр хангана.	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Албан томилолтоор 2 удаа ажиллаж, мэдээг авч нэгтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг Ялбаг, Бугант тосгонд уул уурхайн болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайд эвдэрсэн газрын хяналтын тооллого хийж, хууль бус олборлолтын улмаас эвдрэлд орсон 200 га талбайд 4321.12 м3 овоолго үүссэн болохыг тогтоон, бүртгэлжүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны батлагдсан уулын ажлын 304 төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эвдэрч орхигдсон талбайн нөхөн сэргээлтийг 1719 гаруй га-д 2.4 тэрбум төгрөгөөр хийлгүүлэхээр тусгуулсан.
6.5.1	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээлгүй орхигдсон газруудын талаарх мэдээ, мэдээллээр хангах	-	Үнэн зөв, бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	-	Албан томилолтоор 2 удаа ажиллаж, мэдээг авч нэгтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.	Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын "Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай" 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн No169, A/698, A/336, A/242 дугаартай хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсэг 2021 оны 4 дүгээр сарын 9-13-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг Ялбаг, Бугант тосгонд уул уурхайн болон бичил уурхай, хууль бус олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайд эвдэрсэн газрын хяналтын тооллого хийж, хууль бус олборлолтын улмаас эвдрэлд орсон 200 га талбайд 4321.12 м3 овоолго үүссэн болохыг тогтоон, бүртгэлжүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны батлагдсан уулын ажлын 304 төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд эвдэрч орхигдсон талбайн нөхөн сэргээлтийг 1719 гаруй га-д 2.4 тэрбум төгрөгөөр хийлгүүлэхээр тусгуулсан.
<b>Зорилго-7. Уул уурхайн салбарын хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, шаардлагатай журам, дүрэм, зааврын төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх, мэдээллээр хангана.</b>						
7.1	Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд	-	Үнэн зөв, бодитой, судалгаа мэдээ мэдээлэл, хүргүүлсэн байна.	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн.	Шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>Ашигт малтмалын үнэ ханшийн мэдээллийг 12 удаа нэгтгэн хэтийн төлөвийн мэдээллийг гаргаж, Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны 2021 оны 373 төлөвлөгөө, 568 Х төлөвлөгөө, 2020 оны 194 тайлан, 709 Х тайланг хүлээн авч хянан мэдээллийн санг хөтлөн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хүлээн авсан 52 Техник эдийн засгийн үндэслэлийн мэдээллээр мэдээллийн санг баяжуулж, Ашигт малтмал, газрын тосны газрын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2020 оны тайланг гарган Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж мэдээллээр ханган ажилласан.</li> <li>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрэл, эрэл үнэлгээ, хайгуулын ажил хийгдсэн 10 ордуудын тайланг судалж, 9 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нөхөн төлбөрийн гэрээ байгуулж, нөхөн төлбөрийн дүнг төлж дууссан 3 гэрээг дүгнэж акт үйлдсэн.</li> </ul>

7.1.1	Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник технологийн түвшинг үнэлэх арга, аргачлалын талаар олон улсын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхэд холбогдох суурь судалгаагаар хангах, дэмжлэг үзүүлэн ажиллах	төсөл	Ажлын даалгавар, төсөв боловсруулдаг сан байна. Төсөлд дэмжлэг үзүүлсэн байна.	Ковид-19 цар тахлын улмаас тус ажил хийгдээгүй.	Холбогдох суурь судалгаагаар хангах, дэмжлэг үзүүлэн ажиллана.	<ul style="list-style-type: none"> <li>2021 оны баталгаажсан 239 төлөвлөгөөнөөс олборлолтын болон баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн мэдээллүүдийг авч нэгтгэн мэдээллийн санг баяжуулан ажилласан.</li> <li>2016-2020 онуудад ашиглалтын үйл ажиллагаа явуулж тайлан ирүүлсэн 634 (давхардсан тоогоор) уурхайнуудын олборлолтын болон баяжуулалтын тоног төхөөрөмжүүдийн мэдээллийг авч нэгтгэн техник, технологийн төвшний үнэлгээ хийхэд шаардагдах суурь судалгааг бэлэн болгосон.</li> <li>Ашигт малтмалын төрөл тус бүрээр, хэрэглэж буй технологи, тоног төхөөрөмжийн бүтээл, цаг ашиглалттай холбоотой судалгааг хийж гүйцэтгэж байгаа ба 2021 оны 12 дугаар сарын 15-нд дуусган Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</li> </ul>
7.1.2	Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах талаар судалгаа хийж, үнэлэлт өгч, санал, дүгнэлт гаргах	-	Судалгааны асуулгыг нэгтгэн үнэлэлт өгч, дүгнэлт гаргах	Санхүүжилтийн асуудлаас шалтгаалж ажлыг бусдаар гүйцэтгүүлэх боломжгүй болсон.	Судалгааны асуулгыг нэгтгэж, дүгнэлт гаргаж, цахим хуудсыг шинэчилнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг үнэлэх, сайжруулах боломжийн талаар судалгааны асуулгыг салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг геологи, хайгуул, уул уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалт, хөрөнгө оруулалт, банк санхүүгийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 1850 аж ахуйн нэгжид асуулгыг хүргүүлж, Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудаст 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр байрлуулсан.</li> </ul>
7.1.3	Улс орны эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх аргачлалын талаар судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхэд суурь мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэн ажиллах	Төслийн санхүүжилт	Хууль тогтоомжид нийцүүлэн, шаардлага хангахуйц, үнэн зөв үнэлгээний тайлан гаргана.	Судалгаа хийх үнэлгээний тайлан боловсруулах ажлыг эхлүүлсэн.	Холбогдох суурь судалгаагаар хангах, дэмжлэг үзүүлэн ажиллана.	<ul style="list-style-type: none"> <li>Судалгааны ажилтай холбогдуулан Монгол улсын үндэсний статистикийн хороонд хандаж уул уурхайн салбартай холбоотой судалгааны мэдээ тайланг авахаар тохиролцсон.</li> <li>BGR-ийн төсөлтэй хамтран Хайлуур жоншны зах зээлийн судалгааг 2021 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэхээр тохиролцсон судалгааны ажил хийгдэж байна.</li> <li>Аж ахуйн нэгжүүдээс авсан “Дотоод худалдан авалтын судалгаа”-ны тоон утгыг нэгтгэн урьдчилсан байдлаар Азийн хөгжлийн банкны Хөрөнгө оруулалтын газрын ахлах Э.Энэрэлт, Санхүүгийн албаны ахлах С.Болд нарт 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн.</li> </ul>
7.1.4	Уул уурхайн эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүний судалгаа хийх, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханшийн тухай мэдээллийг цахим хуудсанд сар бүр байршуулах	-	Үнэн зөв мэдээллээр хангаж цахим хуудаст байршуулсан байна.	2020-2025 оны үнийн төсөөллийн судалгаа боловсруулж, мэдээллээр хангаж ажилласан.	12 мэдээ, 1 судалгаа хийсэн байна.	Ашигт малтмалын үнэ ханшийн 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 1-11 дүгээр саруудын үнэ ханшийг судалж, мэдээллийг 12 удаа нэгтгэн гаргаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж, Ашигт малтмал, газрын тосны газрын сар бүрийн Статистик мэдээнд нэгтгүүлэн <a href="http://www.mrpm.gov.mn">www.mrpm.gov.mn</a> цахим хуудаст байршуулахаар Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэст хүргүүлсэн.
